



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/213/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

додд. өд. дд № 1302/112
талай _____ -ны № _____ -г

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 325 ДУГААР
АНГИЙН ЗАХИРАГЧ Г.ЧУЛУУНЗАГД-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- ✓ Бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтагүй, орлогод бүртгэхдээ анхан шатны баримтад үндэслээгүй, баримтын үнэн зөвийг нягтлаагүй, зарцуулалтыг шаардах хуудсаар олгоогүй, замын хуудасны иж бүрдэл хангалтагүй;
- ✓ Шатахууны тооцоог тухай бүр бодож хариуцсан алба хаагчдаар гарын үсэг зуруулаагүй, кассын үйл ажиллагааны бүртгэл хөтлөлт, тайлан гаргалт хангалтагүй;
- ✓ Өөрийн орлого болон орон нутгийн төсөвт байгууллагаас төвлөрсөн бусад орлогыг данс бүртгэлд тусгалгүй кассын няргын хувийн данс руу шилжүүлэн зарцуулсан, ингэхдээ анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, харьяа байгууллагуудаас ирсэн алба хаагчдын хоол хүнс, буудал зэрэгт зориулалт бусаар зарцуулсан;
- ✓ Алба хаагчдад 13 дугаар сарын цалин тооцож кассын няргын хувийн дансанд буцааж авсан, хийгдээгүй ажилд шатахуун зарцуулснаар зарлагадсан, төрийн сангийн харилцах данснаас ногооны үр авах зориулалтаар харилцагч байгууллагад шилжүүлсэн мөнгийг буцаан гаргуулж авсан, кассын зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдоогүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай уулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,

013022955

мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 47 дугаар зүйлийн 47.2 "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна", Зэвсэгт хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.9 "төсөв, хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/мян.төг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	858,554.14	899,424.17
33	АВЛАГА	36,477.90	36,477.90
335	Бусад авлага	36,477.90	36,477.90
3352	Хувь хүмүүсээс авах авлага	36,477.90	36,477.90
34	УРЬДЧИЛГАА	0.00	25,388.80
3471	Урьдчилгаа тооцоо	0.00	25,388.80
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.00	25,388.80
35	БАРАА МАТЕРИАЛ	811,498.24	825,072.07
351	Түүхий эд материал	579,998.32	567,056.47
35110	Тусгай зориулалттай материал	566,903.67	559,981.26
35130	Эм боох материал	3,693.01	7,075.21
35300	Бэлэн бүтээгдэхүүн	17,212.08	62,726.17
354	Хангамжийн материал	207,437.83	181,674.43
35410	Бичиг хэргийн материал	1,120.75	3,760.18
35420	Аж ахуйн материал	279.00	679.60
35430	Сэлбэг хэрэгсэл	14,577.99	11,024.30
35440	Түлш, шатах тослох материал	63,537.30	35,150.14
35450	Барилгын засварын материал	51,146.39	47,464.61
35460	Хүнсний материал	45,851.90	47,134.26
35470	Бусад хангамжийн материал	30,924.51	36,461.33
35600	Мал амьтад	6,850.00	13,615.00
36	НӨӨЦИЙН БАРАА	10,578.00	12,485.40
36200	Хувцасны нөөц	0.00	1,907.40
36600	Бусад нөөц	10,578.00	10,578.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,010,353.63	6,052,949.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,010,353.63	6,052,949.06
392	Биет хөрөнгө	3,705,537.03	4,748,132.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,454,872.16	3,454,872.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-389,301.87	-518,692.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	293,881.23	280,479.23
39204	Хуримтлагдсан элэгдэл	-278,568.73	-270,416.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,878.00	57,525.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,861.56	-41,032.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,875.33	4,868.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,875.33	-4,868.76
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	611,040.67	1,785,800.63
39212	Хуримтлагдсан элэгдэл	-402.88	-402.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,747.68	6,747.68
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,747.68	-6,747.68
393	Биет бус хөрөнгө	1,304,816.60	1,304,816.60
39301	Програм хангамж	1,670.00	1,670.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,670.00	-1,670.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,304,816.60	1,304,816.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,868,907.77	6,952,373.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,491.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,491.18
413	Өглөг	0.00	2,491.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	2,491.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,868,907.77	6,949,882.05
51	Засгийн газрын хувь оролцоо	5,868,907.77	6,949,882.05

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,670,076.85	2,670,076.85
51101	Өмч: - төрийн	2,670,076.85	2,670,076.85
512	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	1,197,196.91	2,278,171.19
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,080,974.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,001,634.01	2,001,634.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,868,907.77	6,952,373.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,779,040.00	8,069,671.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	581,698.13	4,977,451.48
120	Нийтлэг татварын бус орлого	581,698.13	827,750.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	489,229.23	787,684.51
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,522.35	8,446.63
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	482,706.88	779,237.87
120009	Бусад орлого	92,468.90	40,065.50
122	Тусламжийн орлого	0.00	4,149,701.47
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	4,149,701.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,197,341.87	3,092,219.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,184,031.87	2,995,268.37
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,184,031.87	2,995,268.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,310.00	96,951.38
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	9,192.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	76,203.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,310.00	11,555.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,511,028.83	3,420,602.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,511,028.83	3,420,602.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,249,109.62	3,187,496.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,539,358.68	2,470,545.63
210101	Үндсэн цалин	1,546,979.45	1,507,140.04
210102	Нэмэгдэл	836,055.07	819,432.77
210104	Урамшуулал	156,324.16	143,972.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,790.18	92,602.90
210201	Тэтгэврийн даатгал	36,071.52	36,439.21
210202	Тэтгэмжийн даатгал	4,243.71	3,656.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,066.12	2,426.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,005.92	1,188.55

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	50,402.91	48,892.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,367.88	108,928.73
210301	Гэрэл, цахилгаан	50,208.29	37,914.74
210302	Түлш, халаалт	89,575.99	64,964.00
210303	Цэвэр, бохир ус	5,583.60	6,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	121,157.07	103,200.48
210401	Бичиг хэрэг	2,347.89	781.87
210402	Тээвэр, шатахуун	110,238.79	95,857.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,744.00	950.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,239.40	3,030.08
210408	Бараа материал акталсны зардал	4,586.99	2,580.73
2105	Нормативт зардал	118,227.48	103,515.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,349.93	4,446.80
210502	Хоол, хүнс	53,640.09	58,122.61
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,237.46	40,946.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,984.86	114,094.86
210604	Урсгал засвар	2,984.86	114,094.86
2107	Томилолт, зочны зардал	0.00	3,800.00
210702	Дотоод албан томилолт	0.00	3,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,223.47	190,807.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,234.10	30,417.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,568.77	18,076.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,420.60	142,313.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,919.20	233,106.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	256,882.64	232,208.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	256,882.64	232,208.44
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,036.57	897.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,036.57	897.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	268,011.18	4,649,068.88
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	404,533.45	3,568,094.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	289,392.92	3,327,217.26
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	115,140.53	240,877.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-404,533.45	-3,568,094.60
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-136,522.27	1,080,974.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мян.төг /

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,670,076.85	2,001,634.01	1,333,719.18	6,005,430.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,670,076.85	2,001,634.01	1,333,719.18	6,005,430.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-136,522.27	-136,522.27
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,670,076.85	2,001,634.01	1,197,196.91	5,868,907.77
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,670,076.85	2,001,634.01	1,197,196.91	5,868,907.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,670,076.85	2,001,634.01	1,197,196.91	5,868,907.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,080,974.28	1,080,974.28
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,670,076.85	2,001,634.01	2,278,171.19	6,949,882.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,203,864.22	3,100,666.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,522.35	8,446.63
120	Нийтлэг татварын бус орлого	6,522.35	8,446.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,522.35	8,446.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,522.35	8,446.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,197,341.87	3,092,219.74

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,184,031.87	2,995,268.37
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,184,031.87	2,995,268.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,310.00	96,951.38
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	9,192.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	76,203.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,310.00	11,555.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,175,116.79	3,100,666.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,175,116.79	3,100,666.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,913,197.59	2,867,560.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,510,611.25	2,470,545.63
210101	Үндсэн цалин	1,518,232.02	1,507,140.04
210102	Нэмэгдэл	836,055.07	819,432.77
210104	Урамшуулал	156,324.16	143,972.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,790.18	92,602.90
210201	Тэтгэврийн даатгал	36,071.52	36,439.21
210202	Тэтгэмжийн даатгал	4,243.71	3,656.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,066.12	2,426.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,005.92	1,188.55
210205	Эрүүл мэндийн даатгал	50,402.91	48,892.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,878.29	107,433.54
210301	Гэрэл, цахилгаан	50,208.29	37,914.74
210302	Түлш, халаалт	69,086.40	63,468.80
210303	Цэвэр, бохир ус	5,583.60	6,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	102,696.67	77,725.56
210401	Бичиг хэрэг	2,300.00	1,100.00
210402	Тээвэр, шатахуун	97,152.67	72,349.98
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,744.00	1,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500.00	3,075.58
2105	Нормативт зардал	66,911.20	56,086.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000.00	4,325.00
210502	Хоол, хүнс	64,911.20	51,761.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,710.00	58,415.41
210604	Урсгал засвар	8,710.00	58,415.41
2107	Томилолт, зочны зардал	0.00	3,800.00
210702	Дотоод албан томилолт	0.00	3,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,600.00	951.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600.00	951.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,919.20	233,106.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	256,882.64	232,208.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	256,882.64	232,208.44

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,036.57	897.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,036.57	897.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,747.43	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,747.43	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,002,852.10	3,002,817.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,002,852.10	3,002,817.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,770,643.70	2,770,608.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,454,681.90	2,454,681.90
210101	Үндсэн цалин	1,507,140.00	1,507,140.00
210102	Нэмэгдэл	803,569.10	803,569.00
210104	Урамшуулал	143,972.80	143,972.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,249.60	91,214.60
210201	Тэтгэврийн даатгал	35,878.20	35,878.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,590.10	3,590.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,413.20	2,413.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,135.80	1,135.70
210205	Эрүүл мэндийн даатгал	48,232.30	48,197.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,318.50	103,318.50
210301	Гэрэл, цахилгаан	37,914.70	37,914.70
210302	Түлш, халаалт	59,353.80	59,353.80
210303	Цэвэр, бохир ус	6,050.00	6,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,103.60	61,103.60
210401	Бичиг хэрэг	1,100.00	1,100.00
210402	Тээвэр, шатахуун	57,803.60	57,803.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200.00	1,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.00	1,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	56,086.10	56,086.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,325.00	4,325.00
210502	Хоол, хүнс	51,761.10	51,761.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,404.00	3,404.00

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	3,404.00	3,404.00
2107	Томилолт, зочны зардал	800.00	800.00
210702	Дотоод албан томилолт	800.00	800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	232208.40	232208.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	232,208.40	232,208.40
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,208.40	232,208.40
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	201,689,880.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	201,689,880.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,995,268.30	2,995,268.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,583.80	8,446.60

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ мян.төг /	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		96,951.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		96,951.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		96,000.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		15,863.70
210102	Нэмэгдэл		15,863.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,388.30
210201	Тэтгэврийн даатгал		561.00
210202	Тэтгэмжийн даатгал		66.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		13.20
210204	Ажилгүйдлийн даатгал		52.80
210205	Эрүүл мэндийн даатгал		695.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,115.00
210302	Түлш, халаалт		4,115.00
2104	Хангамж, бараа материалын зардал		16,621.90
210402	Тээвэр, шатахуун		14,546.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,075.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		55,011.40
210604	Урсгал засвар		55,011.40
2107	Томилолт, зочны зардал		3,000.00
210702	Дотоод албан томилолт		3,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		951.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		951.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		96951.40

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		96,951.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,192.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		76,203.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		11,555.90

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Б.Жалбаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Н/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зэвсэгт хүчний 325 дугаар анги нь чиг үүргээ “Эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах явдал мөн” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна. Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого 3,203,864.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 32,0386.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувь буюу 20,825.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзээд 2021 оны орлого 3,100,666.4 мянган төгрөгийн 1 хувь 31,006.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	36,477.90	61,866.70	25,388.80
Бараа материал	822,076.20	837,557.50	15,481.30
Үндсэн хөрөнгө	5,010,353.60	6,052,949.10	1,042,595.50
Нийт хөрөнгө	5,868,907.70	6,952,373.30	1,083,465.60
Өр төлбөр	0.00	2,491.20	2,491.20
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,868,907.70	6,949,882.10	1,080,974.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,868,907.70	6,952,373.30	1,083,465.60

Авлага дансны үлдэгдэл 61,866.0 мянган төгрөг болж өссөн нь Могойн гол ХХК-д нүүрсний үнэ 25,388.8 мянган төгрөгийг урьдчилж төлсөнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 837,557.5 мянга болж өссөн нь бусад төсөвт байгууллага болон дээд шатны төсөв захирагчаас 424,730.7 мянган төгрөгийн бараа материалын хангалт хийгдсэн, малын нас дэвшилтийг тооцсон зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,052,949.1 мянган төгрөг болж өссөн нь элэгдлийн зардал болон дараах хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

- ✓ Батлан хамгаалах яамнаас 4,179,701.5 мянган төгрөгийн, ЗХЖШ болон бусад анги байгууллагаас 362,532.2 мянган төгрөгийн, нийт 4,512,233.7 мянган төгрөгийн батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн
- ✓ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 3,328,826.5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 13,408.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,491.2 мянган төгрөг болж өссөн нь шатахууны өглөг бөгөөд засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,949,882.1 мянган төгрөг болж өссөн нь нь хуримтлагдсан үр дүн 1,080,974.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 3,002,852.1 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,995,268.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,583.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,995,268.3 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,446.6 мянган төгрөгийн, нийт 3,003,714.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 3,002,817.2 мянган төгрөгийг зарцуулж, 897.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэхүү буцаан төвлөрүүлэлт нь үндсэн үйл ажиллагааны орлогын давсан хэсэг болон тайлант онд хэмнэгдсэн зардлын зарцуулаагүй үлдэгдэл байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 96,951.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын нөөц сангаас 2021 оны хаваржилт, малчдад туслахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон 4,692.0 мянга, Отгонтэнгэрийг тахиx үйл ажиллагааны зардалд 4,500.0 мянган төгрөг
- Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас 274 дүгээр тусгай салбарын цахилгаан дамжуулах шугам болон халаалтын нэгдсэн системд холбогдох зардалд зориулан олгосон 76,203.5 мянган төгрөг
- Тус байгууллагын өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 11,555.9 мянган төгрөг зэрэг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагаар дамжин Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас хийгдэж буй хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд нь хяналт, шалгалтаас ангид, хяналтгүй байх эрсдэлтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс нууцын чанартай 7 төрлийн 84 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах шаардлагагүй, үлдсэн мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл” үзүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Аудитаар илэрсэн дараах зөрчлийг системийн хэмжээнд шийдвэрлүүлэхээр ҮАГ-т санал хүргүүлж байна.

1. Өмнө нь тус байгууллагад ажиллаж байсан санхүүгийн албаны дарга нь албан тушаалаа урвуулан ашигласны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх Шүүхийн шийдвэрт үндэслэн 36,477.9 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэн бөгөөд уг авлага барагдаагүй байна. Энэхүү авлага нь 014, 325-р анги гэсэн 2 байгууллагатай холбоотой бөгөөд авлагыг байгууллага бүрээр задалж тооцоо нийлээгүйгээс 325-р ангид хамааралтай авлагын дүн тодорхой бус байна.
2. Албан хаагчдад тооцсон сахилгын шийтгэлийн 3,588.5 мянган төгрөгийн орлогыг өөрийн орлогоор бүртгэж, бусад зардалд зарцуулсныг зориулалт бус байна гэж үзлээ.

3. Хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчилд тогтоосон 6,489.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг төсөвт төвлөрүүлэлгүй нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 55,037.2 мянган төгрөгийн зөрчил илэрсний 12,152.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 42,885.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 12,152.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Нэр бүхий алба хаагчдад 13 дугаар сарын цалин бодож кассын няравын хувийн дансанд төвлөрүүлсэн 4,941.2 мянган төгрөгийн зөрчил;
2. Хийгдээгүй ажилд шатахууныг зарцуулснаар зарлагадсан 2.823.5 мянган төгрөгийн зөрчил;
3. Төрийн сангийн харилцах данснаас ногооны үр авах зориулалтаар харилцагч байгууллагад шилжүүлсэн мөнгийг буцаан гаргуулж авсан, кассын зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдоогүй 4,387.3 мянган төгрөгийн зөрчил;

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 42,885.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтгүй байна. Тухайлбал: орлогод бүртгэхдээ анхан шатны баримтад үндэслээгүй, баримтын үнэн зөвийг нягтлаагүй, зарцуулалтыг шаардах хуудсаар олгоогүй, замын хуудасны иж бүрдэл хангалтгүй, шатахууны тооцоог тухай бүр бодож хариуцсан алба хаагчдаар гарын үсэг зуруулаагүй зэрэгтэй холбоотой 29,150.6 мянган төгрөгийн зөрчил;
2. Кассын үйл ажиллагааны бүртгэл хөтлөлт, тайлан гаргалт хангалтгүй байна. Тухайлбал: байгууллагын өөрийн орлого, орон нутгийн төсөвт байгууллагаас олгосон нэмэлт санхүүжилтийг данс бүртгэлээр дамжуулалгүй, кассын няравын хувийн данс руу шилжүүлэн зарцуулсан байна. Ингэхдээ анхан шатны баримтыг бүрдүүлэлт хангалтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, дээд, доод шатны байгууллагаас ирсэн, алба хаагчдын хоол хүнс, буудал зэрэгт зориулалт бус зарцуулсан зэрэг зөрчилтэй холбоотой 13,734.5 мянган төгрөгийн зөрчил;

4.4 Зөвлөмж

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ЗХ-ний 325 дугаар анги	5	55.0			3	12.2	2	42.8		



АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

Б.ЖАЛБАА

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЗАЯА

2022.02.22